

Завханбаялаг ХК-ын 2016 оны үйл ажиллагааны тайлан

Завханбаялаг ХК-ний 2016 оны зорилго зорилтууд, төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр дараах ажлууд хийгдэж компанийн үйлдвэрлэлтийг тасралтгүй явуулсан байна.

1. Шинэ техник технологи нэвтрүүлэх чиглэлээр

- Жимсний шүүс, ундааг төрөл бүрийн жимсээр туршин үйлдвэрлэлд нэвтрүүлж, түүний сав баглаа боодол, хэмжээ, хаяг шошгыг өөрчлөн нэрс, чонын элэг, чацаргана, аньс жимсний 2 төрлийн ундаа шүүсийг үйлдвэрлэж шинээр худалдаанд гаргасан байна.
- Чацарганатай, нэрстэй, аньстай үзэмтэй болон өнгөт үрэл, солонго чихэр, шоколад, амтат чихэр, ургамалын цай зэрэг бүтээгдэхүүнийг шинэ амт чанар, сав баглааг сайжруулан үйлдвэрлэж эхлээд байна.
- Жимсний чанамалын найрлага дахь жимсний эзлэх хувийг ихэсгэн амт чанарт өөрчлөлт оруулсан
- Нэрсний чанамалын савалгааг жижигрүүлж, шинээр лууван, хүрэн манжингийн чанамал үйлдвэрлэлээ.
- Ногоо даршлахад шаардлагатай тоног төхөөрөмж багаж хэрэгслэлээр хангаж алаг салат, байцааны салат, хүрэн манжингийн саладыг үйлдвэрлэж худалдаанд гаргасан байна.
- Төрийн тахилганд зориулж бэлэгний том хайрцаг хийлгэж худалдаанд гаргасан.

2. Чанар удирдлагын тогтолцоог сайжруулах чиглэлээр

- ISO9001-2008 стандартын дагуух чанарын удирдлагын шаардлагуудыг бүх цехийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашиглан хяналт тавьж ажиллаж байна.
- 6 бүтээгдэхүнд Тохирлын тэмдэг хэрэглэх эрх авч, шинээр Баялаг цэвэр усанд тохиролын тэмдэг авсан.
- Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг сунгуулах ажлыг хийж зөвшөөрлийн хугацааг 3 жилээр сунгуулсан.
- Шалгалтын хуудсыг цех тасаг ажлын байр нийтийн эзэмшлийн газар, дэлгүүрүүдэд байрлуулж хяналт тавин ажиллаж байна.
- Дотоодын хяналтын лабораторийн үйл ажиллагааг идэвхжүүлэн, мэргэжлийн ажиллах хүчинээр хангаж, лабораторийн итгэмжлэлийг сунгуулж, итгэмжлэгдсэн лабораторитой болон ажиллаж байна.
- Үйлдвэрлэж буй бүтээгдэхүүний чанар стандартын мөрдөлтийг улирал бүр хөндлөнгийн хяналт хийлгэн ажилласан байна.
- Архины шүүлтүүрийг угааж цэвэрлэж сэргээсэн.

3. Үйлдвэрлэлийн зохицтой дадал, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сайжруулах чиглэлээр

- Ажилчдыг үнэгүй халуун хоол цайгаар тасралтгүй хангаж ажиллаа.
- Ажичдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслэл болон цэвэр ус уух боломж нөхцөлөөр хангаж 2 ш цэвэршүүлсэн ус шүүгч авч байршуулсан.
- Талх, нарийн боовны үйлдвэрлэлд шинээр босголтын шкаф, чаналгын цахилгаан тогоо, бүтээгдэхүүн зөөх тэргэнцэр, ногоо хэрчигч, үр үндэс цэвэрлэгч машин, чанамалын цахилгаан тогоо, бабуулай хийх тоног төхөөрөмж, крем зуурагч сэлүүр, он сар цохигч, жин зэрэг 9,8 сая төгрөгний тоног төхөөрөмж, бусад олон төрлийн хөдөлмөрийн багаж хэрэгслэлээр хангаж гар ажиллагааг хөнгөвчлөх

хөдөлмөрийн бүтээмж дээшлэх, ажиллах таатай орчин бүрдэх бололцоог бий болгосон байна.

- Лабораторын үйл ажиллагааг сайжруулахад зориулж РН метр, 6 хэмжээ бүхий цилиндрүүд , пепетка, штатив,лабораторт шаардлагатай бодисууд зэргийг авч ажиллаж байна.
- ЗАА-н ажилчдад зориулж 2 ш компьютер,принтерээр хангаж ажиллах нөхцлийг сайжруулжээ.
- Чихэр нарийн боовны цехийн ажилчдын хувцас солих өрөөний шкафийг сольсон байна.
- 1,2-р давхарын ОО өрөөг тохижуулж засвар үйлчилгээ хийсэн.
- М-Си-Эс-ийн оффисын өрөөнд засвар хийж өрөөг сольж оруулсан ба санхүүгийн болон захиралын өрөөний хаалгыг сольжээ.

4.Хүний нөөц ажиллах хүчний чиглэлээр

- Компанийн нийт ажилтан ажилчдын ажлын цаг ашиглалт, дотоод журмын хэрэгжилтэнд хяналт тавьж, ажиллан дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллалаа.
- Нийт ажиллагсдыг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сургалтанд 1 удаа хамруулсан
- Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтанд 2 хүнийг хамруулсан.
- УБ хотод Чацаргана жимсний стандарт,стандарчиллын сургалтанд 1 хүн суулгасан байна.
- УБ хотод лабораторийн 17025 стандартын сургалтанд 2 хүн хамруулж, лаборантыг дахин УБ хотод очиж итгэмжлэл авах шалгалтанд хамруулсан.
- Нарийн боовны сургалтанд 5 хүн хамруулсан.
- Хүнсчдийн анхдугаар зөвлөгөөнд 7 хүн оролцож сургалтанд хамарсан.
- Нягтлан бодогчыг Мэргэжсэн нягтлан бодогчын хугацаагүй эрх авах сургалт, шалгалтанд хамруулж амжилттай төгсгөсөн зэрэг ажилтан ажилчдынхаа мэдлэг мэргэжлийг дээшлүүлэхэд анхаарч ажилласан байна.
- Мөн 2016 оны жилийн эцсийн ажлаа дүгнэж тэргүүний ажилчдаа шалгаруулан шагнал урамшуулалт олгож, ажилчдын шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.
- Цагаан сараар өндөр настангуудад болон хүүхдийн баяраар ажилчдын 40 хүүхдэд хүндэтгэл үзүүлж гарын бэлэг өгчээ.
- 2016 онд дууны клипэнд хамтарч ажилласан ба хамтран ажилладаг зарим байгуулагуудын түүхт ой болон өвчтэй зовлонтой үед нь бага хэмжээний дэмжлэг өгч ажиллажээ.
- Мөн Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажиллаж Гадаадын ахмад экспертийн зөвлөгөө авч төлөвлөгөө гарган 14 хоног хамтран ажиллаж нилээд үр дүнтэй ажилласан байна.Мөн зөвлөмжийг биелүүлэх тал дээр манайхан нилээдгүй ажилласан.

5.Туслах аж ахуйн талаар

- Компанийн чацарганын талбайгаас 22,5 тн чацаргана жимс хураан авч үйлдвэрлэлийн үндсэн түүхий эд болгон ашиглаж байна.

- 2016 онд нийт жимс нийлүүлэгч нартай хамтран ажиллаж бөөнөөр 5,0 тонн нэрс жимс, 1,4 тн чонын элэг жимс, 220 кг анис жимс худалдан авч жимсний түүхий эдийн хангарт нийлүүлэлтийн ажлыг хийсэн байна.
- Ажилчид цайны цэцэг навчинд явж цайны материал, гишүүн түүж бэлтгэжээ.

6.Бүтээгдэхүүний борлуулалтын талаар

- Өөрийн нэрийн 2 дэлгүүр, аймгийн төвд Оргил худалдааны төв, баруун бүсийн худалдааны төв, Баянбүрд супермаркет, Санкар, Оргил-ням, Отгонтэнгэр, Хулан, Тод, дэлгүүртэй хамтран ажиллаж байна.
- Тосонцэнгэл сумд Өвөгдэй дэлгүүр, Yr-Op ,Нөмрөг сумын Харз г, Түдэвтэй сумын Шар нуруут дэлгүүр,Шүлүүстэй сумын Должинсүрэн, Усних ,Тэлмэн сумын Тэсийн гол дэлгүүр, Отгон сумын Баатарсүрэн, Цагаанчуулут сумаас Батмөнх, Цагаанхайрхан сумын Биндэрхайрхан зэрэг дэлгүүрүүдтэй хамтран ажиллажээ.УБ хотын төлөөлөгчийн газартай хамтран ажиллаж бараа бүтээгдэхүүнээ борлуулж байна.
- Мөн аймгийн төвийн 1,2 –р цэцэрлэг, 4-р 10 жилийн сургуультай гэрээгээр хамтран ажилладаг ба бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр Аймгийн халамжийн хэлтэсээс зарласан Хүнсний цаасан эрхийн бичгээр хүнсний бүтээгдэхүүн олгох тендерт оролцон шалгарч нийт 43 хүнсний бараа бүтээгдэхүүн борлуулсан байна.

7.Бүтээгдэхүүний зар сурталчилгаа марктенгийг сайжруулах чиглэлээр

- 2016 онд 3 удаа телевизийн зар сурталчилгаа хийлгэн бараа бүтээгдэхүүний хүлээлт үүсгэн ажилласан байна.
- Тахилгын үеэр гудам тайлбайд том болон жижиг сурталчилгааны самбар байршуулж ажилласан байна.
- 2016 оны Завхан аймгийн үзэсгэлэн худалдаанд шинээр хийсэн ногооны саладны амталгааг иргэд хөдөлмөрчдөд, Гадаадын эксперттэй хийсэн бүтээгдэхүүнүүдийн амталгааг ажилчин албан хаагчидад, шинээр хийсэн ундаанууд болон солонго чихрийн амталгааг аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлгөөний төлөөлөгчдөд хийж үнэлгээний хуудсаар дүгнүүлж ажилдаа хэрэгжүүлж ажиллажээ.
- 2016 оны ажлаа аймагтаа үнэлүүлж Дэлхийн чанарын өдрөөр аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэсээс олгодог 2016 оны “ЧАНАРЫГ ЭРХЭМЛЭГЧ БАЙГУУЛЛАГА”-аар мөн орон нутгийн хөгжилд хувь нэмрээ оруулж байгаа бизнес эрхэлдэг аж ахуйн нэгжийг шалгаруулдаг ИНТЕРПРЕНИЕР-2016 шагналыг эзэн болсон ба Орон нутаг бусад аймаг сум, УБ хотын намрын ногоон өдруүд үзэсгэлэн худалдаант амжилттай оролцож ирлээ.

төлсөн байна

2016 оны жилийн тайлангийн үзүүлэлтэнд хийсэн дүгнэлт

цаашид авах арга хэмжээний санал:

1. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах , дотоод нөөц бололцоог ашиглан шинэ ба шинэчилсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

Үүнд: Нээрс, чонын элэг хүрэн манжинг хатааж цай хийх, Луувангаар нухаш хийх мөн түүнчлэн сүү цагаан идээ боловсруулж цех байгуулж ажиллах, Нарийн боовны цехийг өргөтгөн зохион байгуулж, шинэ нэрийн нарийн боов талх үйлдвэрлэх техник технологи эзэмшиж, үйлдвэрлэлийг 5-10 дахин нэмэгдүүлэх,

2. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, эрүүл аюулгүй хүнс үйлдвэрлэх чиглэлээр анхаарч, чихэр нарийн боовны цехид үйлдвэрлэлийн зохистой дадалыг хэвшүүлэхэд анхаарч ажиллах
3. Компанийн удирдлагын орон тоо бүтцийг оновчтой болгож, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган батлуулж ажиллах
4. Улаанбаатар, Эрдэнэт, Хөвсгөл, Говь-Алтайд бараа бүтээгдэхүүн борлуулах ажлыг системтэй хийж борлуулалтын ажлыг эрчимжүүлэх
5. ТУЗ ба хянан шалгагчдын удирдан чиглүүлэх үүрэг ролийг нэмэгдүүлэх
6. Газар тариалан туслах аж ахуйн ажлыг эрчимжүүлэх нэмэгдүүлэх ажлыг хийх
7. Шинээр ноосон нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг ажиллуулах

Компанийн нийгмийн хариуцлагын тайлан

1. Компанийн засаглал

Компанийн засаглалыг компанийн хөгжлийн чухал үзэл баримтлал гэж үздэг бөгөөд хувь нийлүүлэгчдийн эрх ашиг болон мэдээлийн ил тод байдлыг хангах чиглэлийг онцгой анхаардаг.

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх бодлогын хүрээнд дотоодын стандарт шаардлагуудыг мөрдөхийн зэрэгцээ шийдвэр гаргалтын оновчтой, түргэн шуурхай орчныг бүрдүүлэх байдлаар дотоод дүрэм, журмын хэрэгжилтийг мөрдөж ажилладаг.

2. Компанийн нийгмийн хариуцлагын бодлого

Завханбаялаг ХК нь Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд нийгмийн сайн сайхан, улс орон, орон нутгийн эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийг бий болгох зорилт тавин ажилладаг.

Энэ зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа орон нутгийнхаа иргэд, олон нийт, төр засаг санхүүгийн байгууллагад нээлттэй тогтмол тайлагнаж байдаг.

3. Оролцогч сонирхогч талуудын хамтын ажиллагаа

Манай компани нь оролцогч сонирхогч талуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох, харилцан туршлага солилцох зэргээр хамтран ажилладаг.

Энэ дагуу компанийн үйл ажиллагааны чиглэлээр иргэдээс санал зөвлөмж авах, МУИС-ын харьяа Завхан дахь салбар сургуулийн сурагчдыг оролцуулан судалгаа хийх, нээлттэй өдөрлөг бүтээгдэхүүний амталгааг хийлгэх зэргээр ажиллаж байна.

4.Өргөдөл гомдол барагдуулах механизм

Компаниас үйлдвэрлэн гаргаж байгаа бүтээгдэхүүнээ нь цэвэр экологийн байгалийн түүхий эдээр үйлдвэрлэхийг эрмэлздэг ба хүний эрүүл мэндэд аюулгүй байдлыг эрхэмлэж мөн байгальд ямар нэгэн хор хөнөөл сөрөг нөлөө үүсч боолзошгүй нөхцлийг байнга хянаж орон нутгийн иргэдээс санал гомдол хүлээн авч ажилдаа хэрэгжүүлж ажилладаг.

Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан

Манай компани нь тогтвортой хөгжлийг дараах үйл ажиллагаа , түүний гүйцэтгэлээр хэмждэг.

- Байгаль орчны талаар хүлээсэн үүргээ ухамсарлаж үлгэр жишээч байх
- Нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах
- Үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийнхаа эдийн засгийн хөгжлийг дэмжих
- Компанийн засаглал, ёс зүй, хууль дүрмийн хэрэгжилтийг чанд сахих зэрэг болно.

Байгаль орчинд учрах аливаа нөлөөллийг зохицуулах, орон нутгийн иргэдтэй харилцах, ажиллагсдаа сургах, ханган нийлүүлэгчдийг сонгох зэрэг компанийн бүхий л үйл ажиллагаанд энэхүү тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн ажлын арга барилыг ашигладаг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг холбогдох хуулийн дагуу хийж гүйцэтгэв.

Тус компанийд ирүүлсэн олон тооны хүсэлт, саналыг хүлээн авч, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд урт хугацааны үр өгөөжтэй, нийгмийн өмнө тулгамдсан аливаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөр, санал санаачилгыг дэмжин ажилладаг.

Компанийн үндсэн, гэрээт ажилтан байхаас үл хамааран тэдний эрхийг дээд зэргээр хүндэтгэсэн, өрсөлдөхүйц цалин урамшуулал олгож, тохилог, аюул осолгүй, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй ажлын орчноор хангахад анхаарч ажилладаг.

Завханбаялаг ХК –ын дотоод журамд заасан ажиллагсдын нийгмийн халамжийн заалтууд Монгол Улсын Хөдөлмөрийн хуульд заасан хэмжээнээс ч зарим тохиолдолд илүү таатай нөхцөл байдлыг санал болгодог. Тухайлбал ажиллагсад өөрийгөө хөгжүүлэх сургалтад хамрагдсан тохиолдолд сургалтын зардлыг нь компанийс олгодог олон давуу тал бий.

Мөн компани ажиллагсдын төлөөлөл болох Үйлдвэрчний эвлэлийн байгууллагатай хамтын гэрээ байгуулсан юм.

Орон нутгийнхаа эдийн засагт хэвь нэмэр оруулж төсвийн орлогыг бүрдүүлж 2016 онд ОАТатварт 108,9 сая төгрөг, НӨАТ-т худалдан авалттай нийлээд 28,1

сая төгрөг, бусад татварт 3,7 сая төгрөг нийтдээ 140,7 сая төгрөг татварт төлсөн байна.

Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

Мэдээлэл аудитын компаниар баталгаажуулсан Завханбаялаг ХК-ны 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүний иайлбар тодруулга, дүгнэлтийн хамтаар 2017 оны 02-р сарын 08-ны А/06 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл гэрээ байхгүй.

Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ болон хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа $619,5:30,0=20,6$ /20:1/ байна.

2016 онд авсан зээл байхгүй.

2016 онд өмнөх жилтэй харьцуулбал: борлуулалт 63,5 сая төгрөг буюу 17,6%-иар өссөн. Ашиг мөн урьд онтой харьцуулахад 15,2 %-иар буурсан. Энэ нь 2016 онд архины болон дарсны тусгай зөвшөөрөл авсан зардал гарсантай холбоотой гэж дүгнэлээ.

Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээллийг www.mse.mn сайтнаас харна уу.